



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/006/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Сүхбаатар сум
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх
Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Отгонбаяр
Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Аудитор: О.Анхбаяр
Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.МӨНХТӨР
ТАНАА

2026.03.28 № СА-2026/006/НА-СА-ТТЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,578,413.4 мянган төгрөг буюу 91.4 хувьтай байгаа нь урсгал зардлыг 395,223.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 154,587.9 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 165,551.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4326050370

Тайлант онд төсвийн зарцуулах эрх тавигдаагүйгээс шалтгаалан байгууллагад төлөх өглөг 121,272.4 мянган төгрөгийн, хувь хүнд төлөх 1,610.0 мянган төгрөгийн, зэрэг нийт **122,882.4** мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сайхан сумын Засаг дарга нь тайлант онд 16 зорилтын хүрээнд 91 ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж 85.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл 1324100015 9055436
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,790,050.4	1,460,205.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		1,408,142.9	858,784.6
33	АВЛАГА		279,611.4	447,672.1
35	БАРАА МАТЕРИАЛ		102,296.1	153,749.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		8,486,881.3	9,237,319.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		8,486,881.3	9,237,319.5
39200	Биет хөрөнгө		7,935,708.5	8,674,296.8
39300	Биет бус хөрөнгө		551,172.7	563,022.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		10,276,931.6	10,697,525.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		91,280.0	150,066.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		91,280.0	150,066.4
41300	Өглөг		91,280.0	150,066.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		10,185,651.7	10,547,458.8
51	Засгийн газрын хувь оролцоо		10,185,651.7	10,547,458.8
51100	Засгийн газрын оруулсан капитал		793,055.1	793,055.1
51200	Хуримтлагдсан үр дүн		8,509,424.9	8,871,232.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		883,171.7	883,171.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		10,276,931.6	10,697,525.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		9,953,588.2	8,793,832.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		5,206,778.3	6,064,411.8
110	Орлогын албан татвар		4,121,744.3	4,945,735.7
1100	Хувь хүний орлогын албан татвар		4,466,409.9	5,282,420.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(344,665.6)	(336,685.1)
113	Хөрөнгийн албан татвар		801,369.6	691,078.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		283,664.4	427,597.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		3,930,171.2	2,729,420.3
120	Нийтлэг татварын бус орлого		3,930,171.2	2,201,780.0
122	Тусламжийн орлого		0.0	8,798.6
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		0.0	518,841.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		816,638.7	0.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		5,818,851.0	7,387,826.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,818,851.0	7,387,826.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,592,364.2	7,028,755.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,585,677.0	1,979,453.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		201,763.1	236,689.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,657,233.0	2,992,471.3
2104	Хангамж, бараа материалын зардал		139,319.7	190,578.2
2105	Нормативт зардал		6,729.8	8,866.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		204,381.5	285,855.3
2107	Томилолт, зочны зардал		11,911.0	9,140.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,810.0	181,117.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	704,539.1	1,144,583.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	226,486.8	359,071.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,134,737.2	1,406,005.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,380,803.4	1,044,198.1
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(1,380,803.4)	(1,044,198.1)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	2,753,933.8	361,807.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	792,655.1	883,171.7	5,763,648.9	7,439,475.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	(8,157.8)	(8,157.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	792,655.1	883,171.7	5,755,491.1	7,431,317.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	400.0	0.0	0.0	400.0
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	2,753,933.8	2,753,933.8
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	793,055.1	883,171.7	8,509,424.9	10,185,651.7
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	793,055.1	883,171.7	8,509,424.9	10,185,651.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	793,055.1	883,171.7	8,509,424.9	10,185,651.7
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	361,807.1	361,807.1
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	793,055.1	883,171.7	8,871,232.0	10,547,458.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,540,559.3	7,189,740.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	5,206,778.2	6,064,411.8
110	Орлогын албан татвар	4,121,744.3	4,945,735.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,466,409.9	5,282,420.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(344,665.6)	(336,685.1)
113	Хөрөнгийн албан татвар	801,369.6	691,078.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	283,664.4	427,597.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	176,464.2	224,867.0
1181	Газрын төлбөр	102,059.2	200,547.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,141.0	2,183.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	495,125.5	1,125,328.8
120	Нийтлэг татварын бус орлого	495,125.5	590,108.4
122	Тусламжийн орлого	0.0	16,378.6
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	518,841.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	838,655.6	0.0

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,197,110.9	6,516,363.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,197,110.9	6,516,363.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,970,624.2	6,157,292.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,587,837.8	2,044,571.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201,763.1	238,696.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,583,262.6	2,980,131.6
2104	Хангамж, бараа материалын зардал	127,456.5	148,545.3
2105	Нормативт зардал	9,843.2	8,149.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,566.5	312,243.3
2107	Томилолт, зочны зардал	11,911.0	7,530.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,380.1	187,714.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168,603.4	229,710.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	226,486.8	359,071.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,343,448.4	673,376.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,509,749.6	1,102,735.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,509,749.6	1,102,735.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1,509,749.6	1,102,735.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,509,749.6)	(1,102,735.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	8,157.8	120,000.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(8,157.8)	(120,000.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(174,459.0)	(549,358.3)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,582,601.9	1,408,142.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,408,142.9	858,784.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,889,307.3	6,991,839.1	102,531.8	101.5
11	Татварын орлого	5,860,465.6	6,064,411.8	203,946.2	103.5
110	Орлогын албан татвар	4,647,077.5	4,945,735.7	298,658.2	106.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,992,077.5	5,282,420.8	290,343.3	105.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(345,000.0)	(336,685.1)	8,314.9	97.6
113	Хөрөнгийн албан татвар	795,599.5	691,078.2	(104,521.3)	86.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	417,788.6	427,597.9	9,809.3	102.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	208,496.1	224,867.0	16,370.9	107.9
1181	Газрын төлбөр	206,102.5	200,547.5	(5,555.0)	97.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,190.0	2,183.3	(1,006.7)	68.4
12	Татварын бус орлого	1,028,841.7	927,427.3	(101,414.4)	90.1
120	Нийтлэг татварын бус орлого	510,000.0	408,585.6	(101,414.4)	80.1
122	Тусламжийн орлого	0.0	0.0	0.0	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	518,841.7	518,841.7	0.0	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,293,775.7	7,578,413.4	(715,362.3)	91.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,808,438.7	6,413,215.3	(395,223.4)	94.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,435,509.7	6,054,144.3	(381,365.4)	94.1

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,643,591.0	1,553,441.3	(90,149.7)	94.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	216,200.2	188,368.3	(27,831.9)	87.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,058,539.3	2,917,074.3	(141,465.0)	95.4
2104	Хангамж, бараа материалын зардал	102,455.2	80,710.0	(21,745.2)	78.8
2105	Нормативт зардал	2,572.5	0.0	(2,572.5)	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	347,873.5	340,082.4	(7,791.1)	97.8
2107	Томилолт, зочны зардал	17,237.3	7,290.0	(9,947.3)	42.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	803,564.0	741,967.1	(61,596.9)	92.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	243,476.7	225,210.9	(18,265.8)	92.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	372,929.0	359,071.0	(13,858.0)	96.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,199,786.0	1,045,198.1	(154,587.9)	87.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	285,551.0	120,000.0	(165,551.0)	42.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(1,404,468.4)	(586,574.4)	817,894.0	41.8
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,404,468.4	586,574.4	(817,894.0)	41.8
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,404,468.4	586,574.4	(817,894.0)	41.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	1,405,580.4	1,405,580.4	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	829,727.3	829,727.3	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	101	97	(4.0)	96.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	49	47	(2.0)	95.9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	49	47	(2.0)	95.9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	16,378.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,378.6
122	Тусламжийн орлого	16,378.6
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,657.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,657.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,657.4
2104	Хангамж, бараа материалын зардал	782.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	375.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500.0
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	10,721.3
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(10,721.3)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(10,721.3)

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 259,706.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,454.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 255,252.5 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөгдөж бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	4,454.2	3	4,454.2	100.0
Албан шаардлага	6	255,252.5	6	255,252.5	100.0
Зөвлөмж	2	0.0	2	0.0	100.0
Нийт дүн	11	259,706.7	11	259,706.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **100,366.6** мянган төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулсан. Үүнд:

ЗДТГ:

- Бараа материалын 61,222.8 мянган төгрөгийг аж ахуйн материалд бөөн дүнгээр тайлагнасан,
- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хөрөнгийн орлогыг 36,544.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,


Номгон Захирагчийн алба:

- Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардлын 2,599.8 мянган төгрөгийг буруу зардалд тайлагнасан

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27, Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 1-р хавсралтаар баталсан “Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын 2.3, 2.4(б) дэх заалтууд болон “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт **30,720.3** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 25,876.8 мянган төгрөгийн 6 албан шаардлага, 4,843.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **30,720.3** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **21,471.8** мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.



5.1 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **10,920.1** мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

ЗДТГ:

- Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлийн зардлаас сэлбэг хэрэгслийн зардалд 518.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 380.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 440.0 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардалд 799.1 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас мэдээлэл технологийн зардалд 596.0 мянган төгрөг, түрээсийн зардалд 650.0 мянган төгрөг,
- Урсгал засварын зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 784.5 мянган төгрөг, Хот тохижилт, үйлчилгээний газрын хөрөнгөд бүртгэлтэй усан оргилуурыг засварлах зардалд 6,302.5 мянган төгрөг,

Номгон Захирагчийн алба:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас мэдээлэл технологийн зардалд 450.0 мянган төгрөг,

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

2. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс ЗДТГ нь **3,106.5** мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

1324100015 9055436

3.Тайлант онд ЗДНХ-өөс жил бүр давтагддаг, урьдчилан төлөвлөх боломжтой муур устгал, нохой устгал зэрэг зориулалт бус зардалд **5,000.0** мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “*Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам*”-ын 2.1 дэх *Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна: 2.1.5: энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

4.“Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ нь **4,470.0** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “*зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх*”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.“Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ нь тайлант хугацааны эцэст татварын байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайланд **2,380.2** мянган төгрөгийн татварын өр төлбөрийг дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, 20.2.7 дахь “*аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, ...*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайланд хугацааны эцэст харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: Номгон тосгоны Захирагчийн алба нь өмч хамгаалах зөвлөлийн хурлаар засвар үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх, төсөв тооцоо, судалгаа зэрэг асуудлыг хэлэлцүүлж, дүгнүүлэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд нийт **4,843.5** мянган төгрөгийг зарцуулсан.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Анхан шатны хүчин төгөлдөр баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 59 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох болон актлах саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн ХЗУ²4-д "... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон актлах эсэх саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	97,766.8			1	97,766.8	1	97,766.8				
Номгон Захирагчийн алба	1	2,599.8			1	2,599.8	1	2,599.8				
Дүн	1	100,366.6			1	100,366.6	1	100,366.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	5,000.0			1	5,000.0						
ЗДТГ	2	13,576.6			2	13,576.6						
Захирагчийн алба	2	5,293.5			1	450.0	1	4,843.5				
Хот тохижилт	3	6,850.2			2	6,850.2	1					
ТТЗ-ийн Дүн	8	30,720.3			6	25,876.8	2	4,843.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
Дүн	1				1			
Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилттэй холбоотой								
Төсөл, арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолт зэргийг урьдчилан хийлгүйгээр, ИТХ-аар батлуулсны дараа гүйцэтгүүлсэн	1	220,000.0			1	220,000.0		
Дүн	1	220,000.0			1	220,000.0		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтыг зөрчсөн	2	1,247.0			2	1,247.0		
Дүн	2	1,247.0			2	1,247.0		
Нийт дүн	4	221,247.0			4	221,247.0		